

ДОРНОГОВЬ АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН
2025 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН БИЕЛЭЛТ

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт	Гүйцэтгэлийн хувь
ЗОРИЛГО.УЛСЫН БҮРТГЭЛИЙН НЭГДСЭН ТОГТОЛЦООГ БҮРДҮҮЛЖ, ИРГЭНИЙ, ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН, ЭД ХӨРӨНГИЙН ЭРХИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЦАХИМЖУУЛЖ, ТЕХНИК, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ, ПРОГРАММ ХАНГАМЖИЙГ САЙЖРУУЛАХ. /“Алсын хараа-2050” зорилт 5.3, “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн 5.3, “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”, Улсын бүртгэлийн байгууллагын 2025-2028 оны стратеги төлөвлөгөө/							
ЗОРИЛТ1. ДЭВШИЛТЭД ТЕХНОЛОГИД СУУРИЛСАН ТӨРИЙН ЦАХИМ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БАЙГУУЛЛАГА БАЙНА.							
1.1.	Шинээр хэрэглээнд нэвтрүүлсэн Улсын бүртгэлийн цахим гэрчилгээгээр иргэд олон нийтэд үйлчилгээ үзүүлэх	Үйл ажиллагаа	Цахимаар олгосон эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээний тоо	0	5	Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбарыг QR кодтой хэвлэх хөгжүүлэлтийг гүйцэтгэж e-mongolia цахим системээр дамжуулан цахимаар авах боломжтой болсны дагуу орон нутгийн иргэд, олон нийтэд сурталчилан мэдээллэж зарим иргэдэд e-mongolia цахим системийн “миний бичиг баримтууд” цэснээс үл хөдлөх эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбараар үйлчилгээ үзүүлсэн. Мөн “Барьцаа хөрөнгө чөлөөлсөн” тухай албан бичиг цахим хэлбэрт шилжүүлсэнтэй	80%

						холбогдуулан Монголын ипотекийн корпорациас цахимаар eprs2 програмд "Барьцааны гэрээ дуусгавар болсон тухай" 330 албан бичиг илгээснийг тухай бүр шийдвэрлэн ажилласан. Тухайн арга хэмжээнд дурдсан Улсын бүртгэлийн цахим гэрчилгээ хэрэглээнд нэвтрээгүй байна.	
1.2.	Иргэний үнэмлэх хэвлэх үйл ажиллагааг орон нутаг дахь зарим нэгжид хэвлэх боломжийг бий болгох, хууль эрх зүйн орчныг бүрдүүлэхэд санал хүргүүлэх	Үйл ажиллагаа	Хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэхэд хүргүүлсэн саналын тоо	0	1	Тус арга хэмжээний хүрээнд Аймгийн Засаг дарга О.Батжаргалтай уулзалт зохион байгуулж орон нутагт иргэний үнэмлэх болон үндэсний энгийн гадаад паспортын хэвлэх үйлдвэрийг байгуулах талаар санал солилцсон. Хэвлэх үйлдвэр буюу хэвлэгч төхөөрөмжийг нийлүүлдэг ААНБ-тай уулзалт зохион байгуулж үнийн санал, холбогдох мэдээллийг авч 2026 оны орон нутгийн төсөвт шаардагдах хөрөнгө болох 587 сая төгрөгийг тусгуулахаар 2025 оны 08 сарын 04-ний өдрийн 18/604 дугаар албан бичгээр санал хүргүүлсэн.	90%
1.3.	Иргэд, олон нийтэд тоон гарын үсэгний ач холбогдолыг сурталчилан таниулах, хэрэглээг нэмэгдүүлэх, шинээр олгох талаар арга хэмжээ зохион байгуулах	Үйл ажиллагаа	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	-	3	Тайлант онд нийт 6647 тоон гарын үсгийг иргэдэд олгосон бөгөөд улсны бүртгэгч нар 4643 иргэнд, Хаан банк киоск машинаас 849 иргэнд, Төрийн цахим үйлчилгээний төвөөс 1155 иргэнд тус тус тоон гарын үсгийг олгосон байна. Улсын бүртгэлийн үйл ажиллагааг иргэд, олон нийтэд ойртуулж, төрийн үйлчилгээг чирэгдэлгүй, түргэн шуурхай хүргэх, мэдээ мэдээлэл, зөвлөмж, зөвлөгөө өгөх, тоон гарын үсгийн ач холбогдлыг сурталчилан таниулах болон тоон гарын үсэг олгоход төр, хувийн хэвшил, иргэний хамтын ажиллагааг нэмэгдүүлэхээр "Тоон гарын үсгээ тогтмол	100%

						хэрэглэе” арга хэмжээг 2025 оны 11 дүгээр сард зохион байгуулсан. Тус арга хэмжээг батласан удирдамжийн дагуу Хаан банк, Төрийн банк, Голомт банк, Худалдаа хөгжлийн банкны аймаг дахь салбаруудтай хамтран үйлчилгээ авч буй иргэдэд тоон гарын үсгийн ач холбогдлыг сурталчилан таниулах, тоон гарын үсгийг олгож ажилласан. Мөн үүрэн телефоны Юнител компанитай хамтран ажиллаж “one call” үйлчилгээний дуудлага хэсэгт хэрэглээ ач холбогдлыг талаарх богино яриаг байршуулан ажилласан. Мөн тухайн онд Сайншанд, Замын-Үүд, Айраг, Дэлгэрэх, Хатанбулаг зэрэг сумдад нийт 16 удаагийн нээлттэй арга хэмжээг зохион байгуулсан бөгөөд тоон гарын үсгийг тухай бүр олгон ажилласан.	
1.4.	Төрийн болон хууль хяналтын байгууллагад цахимаар лавлагаа, мэдээлэл үзүүлэх, хуулбар олгох үйлчилгээ нэвтэрсний дагуу орон нутагт цахимаар үйлчилгээ үзүүлэх	Үйл ажиллагаа	Цахимаар үзүүлсэн лавлагаа, мэдээллийн хувь	0%	100%	Төрийн байгууллага болон төрийн тодорхой чиг үүргийг гүйцэтгэж байгаа хуулийн байгууллагын үндсэн систем болон албан бичиг солилцооны дундын системээр дамжуулан 856 иргэний лавлагаа, мэдээллийг тухай бүр олгож цахимаар үйлчилгээ үзүүлсэн байна.	100%
1.5.	Шинээр үйл ажиллагаанд нэвтрүүлсэн гадаад паспорт захиалгын цахим машиныг орон нутагт	Орон нутгийн төсөв	Зохион байгуулсан уулзалтын тоо	-	1	Замын-Үүд суманд 2025 оны 09 дүгээр сарын 11-ний өдөр, Хатанбулаг сумын Ханги боомтод 2025 оны 10 дугаар 09-ний өдөр тус тус ажилласан бөгөөд сумдын удирдагууд болон Хилийн цэргийн 0108 дугаар ангийн шалган нэвтрүүлэх тасгийн удирдлага болон	100%

	хэрэглээнд нэвтрүүлэхэд сумдын удирдлагуудтай уулзалт зохион байгуулах, сурталчилан таниулах					авто зам, төмөр замын боомтын удирдлагуудтай уулзалт зохион байгуусан. Уулзалтаар гадаад паспорт захиалгын цахим машины хэрэгцээ ач холбогдлыг танилцуулсан бөгөөд Замын-Үүд суманд гадаад паспорт захиалгын цахим машиныг бусад төрийн киоск төхөөрөмжүүдтэй хамт байршуулан “Цахим төв” байгуулахаар сумын удирдлагуудтай харилцан тохиролцсон. 2026 оны орон нутгийн төсөвт шаардлагатай төсвийг тусгуулахаар 2025 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн албан бичиг хүргүүлсэн.	
1.6.	Хуулийн этгээдийн улсын бүртгэлийг харьяалал харгалзахгүй бүртгэх талаар ирүүлсэн чиглэлийн дагуу арга хэмжээг авч хэрэгжүүлэх	Үйл ажиллагаа	Харьяалал харгалзахгүй бүртгэсэн хуулийн этгээдийн тоо	0	5	Улсын бүртгэлийн үйлчилгээг иргэн, хуулийн этгээдэд хөнгөвчлөх зорилгоор улсын бүртгэлд бүртгүүлэх өргөдлийг цахим хэлбэрээр авах, хуулийн этгээдийн нэр авах хүсэлтийг цахим хэлбэрээр гаргах зохицуулалтын дагуу e-mongolia, e-business.mn системээр дамжуулан 1875 иргэнээс ирүүлсэн хуулийн этгээдийн нэр авах, баталгаажуулах хүсэлтийг хуулийн этгээдийн улсын бүртгэлийн нэрийн санд шалгаж 331 хуулийн этгээдийн нэрийг баталгаажуулан, 17 цахим гэрчилгээг олгож харьяалал харгалзахгүй бүртгэлийг гүйцэтгэсэн байна.	90%
1.7.	Хаягийн болон газар, үл хөдлөх эд хөрөнгийн дундын мэдээллийн сан байгуулах, өөрчлөлт оруулах, хаягийн мэдээллийн сангийн нэгдсэн системийг хэрэглээнд нэвтрүүлэхэд орон	Үйл ажиллагаа	Газар, үл хөдлөх эд хөрөнгийн хаягийн дундын мэдээллийн сан үүсгэх ажилтай холбоотой авч	2	2	Тус ажлын хүрээнд аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газартай уулзалт зохион байгуулж газар, үл хөдлөх эд хөрөнгө гэрчилгээ олгох асуудал, гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээдийн шилжилт хөдөлгөөний асуудал, хаягийн асуудал болон иргэнд өмчлүүлсэн газрын мэдээллийн сангийн зөрүүтэй байдлыг арилгах дундын мэдээллийн сан үүсгэх ажлыг хамтран гүйцэтгэхээр	100%

	нутгийн зүгээс авч хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах		хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо			тохиролцсон. Энэхүү ажлын үр дүнд хамтран ажиллах тухай “Санамж бичиг”-ийг 2025 оны 11 сарын 11-ний өдөр байгуулсан. Газар болон эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн мэдээллийн санд Айраг сум-15, Алтанширээ-2, Даланжаргалан сум-6, Дэлгэрэх сум-4, Сайншанд сум-52, Замын-Үүд сум-27, Иххэт сум-13, Мандах сум-7, Өргөн сум-2, Хатанбулаг сум-5 нийт 133 хаягийн мэдээллийг цахим системд оруулсан байна. Мөн төрөөс хувьчилсан газрын өмчлөх эрхийг бүртгэх бүртгэл-535, газраас бусад үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхийг анх удаа бүртгэх 222 бүртгэлийг бүртгэж хаягийн мэдээллийн нэгдсэн систем дэх хаягийн баяжилтыг нэмэгдүүлсэн.	
ЗОРИЛТ 2. ОРЧИН ҮЕИЙН ШИНЭ ТЕХНИК, ТЕХНОЛОГИ, МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙГ ҮЙЛ АЖИЛЛАГААНДАА НЭВТРҮҮЛЖ, ТӨРӨӨС ИРГЭН, ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ҮЗҮҮЛЭХ УЛСЫН БҮРТГЭЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮРТЭЭМЖ, ШУУРХАЙ БАЙДЛЫГ НЭМЭГДҮҮЛНЭ.							
2.1.	Улсын бүртгэлийн хэлтсийн ажлын байрны байршлыг сайжруулах, стандартад нийцүүлэх ажлыг зохион байгуулах	Орон нутгийн төсөв	Зохион байгуулсан ажлын тоо	-	1	Тус ажлын хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлээд байна. - Хэлтсийн даргын 2025 оны “Ажлын хэсэг байгуулах тухай” А/17 дугаар тушаалаар төрийн үйлчилгээг иргэдэд стандартын шаардлага хангасан заал, танхимаар үйлчилгээ үзүүлэх зорилгоор Сайншанд сумын хэмжээнд хэлтсийн албан хаагчдыг стандартын шаардлага хангасан эрүүл, аюулгүй орчинд ажиллуулах, байрны судалгаа явуулж, ажлын байр сэлгэн орох болон барилга байгууламжийг судлах ажлын хэсгийг байгуулсан. - Сайншанд сумын хэмжээнд ажлын байрны судалгаа явуулж оффисын	100%

						зорилулттай баригдаж буй “Саруул талын өргөө” ХХК-ийн удирдлагатай уулзалт зохион байгуулж одоо баригдаж буй барилгын зохион байгуулалттай танилцаж, 2025 оны 12 дугаар сард 350 м2 талбайг түрээслэхээр тохиролцсон. Мөн аймгийн Засаг дарга О.Батжаргал болон аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга Н.Алдарбаяр нартай уулзалт зохион байгуулж харилцсан зөвшилцсөн бөгөөд ажлын хэсгийн дүгнэлт саналыг УБЕГ-т хүргүүлэн ажилласан.	
2.2.	Эд хөрөнгө, хуулийн этгээд, иргэний улсын бүртгэлийн үйл ажиллагааг сайжруулах, алба хаагчдын ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх үйлчилгээний сэтгэл ханамж, чанар хүртээмжийг дээшлүүлэх зорилгоор хэрэгжүүлж буй процессийн дахин инженерчлэлийн ажлыг дэмжин ажиллаж хэлтсийн хэмжээнд хөтөлбөрийн хэрэгжилтийг ханган ажиллах	Үйл ажиллагаа	Эд хөрөнгө, хуулийн этгээд, иргэний улсын бүртгэлийн үйл ажиллагаа сайжирч, гарсан үр дүнгийн хувь	50%	100%	Эд хөрөнгө, хуулийн этгээд, иргэний улсын бүртгэлийн үйлчилгээг үзүүлэхэд өөрт байгаа мэдээллийг иргэдээс авахгүй, хурууны хээг уншуулан улсын бүртгэлийн үйлчилгээг хүнд сурталгүй, түргэн шуурхай үзүүлж процессийн дахин инженерчлэх ажлыг дэмжин иргэний улсын 26072 бүртгэл, Эд хөрөнгийн 7521 бүртгэл, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн 1567 үйлчилгээ нийт 35250 бүртгэлийг гүйцэтгэн ажилласан.	100%

2.3.	Сумдын ЗДТГ-тай хамтран “Танд ойрхон төрийн үйлчилгээ” арга хэмжээ зохион байгуулах	Үйл ажиллагаа	Сумдад зохион байгуулсан арга хэмжээний тоо	4	13	Тайлант хугацаанд нийт 10 суманд 16 удаагийн арга хэмжээ зохион байгуулж ажилласан. Үүнд - Сайхандулаан суманд 02 дугаар сарын 03-нд, 5 сарын 20-нд, - Эрдэнэ суманд 04 дугаар сарын 29-нд, 06 дугаар сарын 06-нд, - Даланжаргалан суманд 02 дугаар сарын 17-18, 03 дугаар сарын 19-25-ны өдрүүдэд, - Хатанбулаг суманд 06 сарын 03-06-ны өдрүүдэд, - Хатанбулаг сумын Ханги мандалын боомтод 10 дугаар сарын 09-ний өдөр - Өргөн сум 02 дугаар сарын 15, 04 дүгээр сарын 10-ны өдрүүдэд, - Иххэт суманд 05 дугаар сарын 23-ны өдөр, 07 дугаар сарын 04-ний өдөр, - Улаанбадрах суманд 01 дүгээр сарын 21, 05 дугаар сарын 19,20-ны өдрүүдэд нээлттэй хаалганы өдөрлөг, - Замын-Үүд суманд 09 дүгээр сарын 11-ний өдөр - Сайншанд суманд 05 дугаар сарын 01-ний өдөр “Танд ойрхон төрийн үйлчилгээ” өдөрлөгийг тус тус зохион байгуулж нийт 2014 иргэнд улсын бүртгэлийн үйлчилгээг үзүүлсэн байна.	100%
2.4	Сумдын улсын бүртгэгч нарт үндэсний энгийн гадаад паспортын захиалга хүлээн авах, түгээх үйлчилгээний	Үйл ажиллагаа	Үндэсний энгийн гадаад паспорт захиалах боломжтой болсон	2	12	Төрийн үйлчилгээг түргэн шуурхай, чирэгдэлгүй хүргэх зорилгоор бүх сумдад буюу 14 сумдад үндэсний энгийн гадаад паспорт захиалах үйлчилгээг нээж 1859 иргэнд үндэсний энгийн гадаад паспорт олгоод байна. Гадаад паспортыг сумын иргэдэд эрсдэлгүй, аюулгүй, шуурхай хүргэх	100%

	эрхийг нээлгэж орон нутгийн иргэдэд төрийн үйлчилгээг түргэн шуурхай хүргэх		сумдын тоо			зорилгоор “Монгол шуудан”-гийн Дорноговь аймаг дахь салбартай гэрээ байгуулан “Дотоодын энгийн шуудан үйлчилгээ”-ний хамгийн бага тариф болох 4650 төгрөгөөр хүргэлтийн үйлчилгээг үзүүлж байна.	
2.5.	Хуулийн этгээдийн бүртгэл хийх эрхийг холбогдох албан хаагч нарт нээлгэж орон нутгийн иргэдэд төрийн үйлчилгээг түргэн шуурхай хүргэх	Үйл ажиллагаа	Хуулийн этгээдийн бүртгэл хийх эрхтэй болсон улсын бүртгэгчийн тоо	10	2	Тус хэлтсийн 10 улсын бүртгэгч тус эрхийг нээлгэсэн бөгөөд одоогоор иргэдэд төрийн үйлчилгээг түргэн шуурхай хүргэн ажиллаж байна. Харин Айраг сумын улсын бүртгэгч Б.Уранчимэг, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэгч Б.Номин-Эрдэнэ нарт хуулийн этгээдийн улсын бүртгэл хөтлөх эрх нээлгэхээр УБЕГ-т 2025 оны 18/02, 18/21 дугаар албан бичгийг тус тус хүргүүлсэн.	100%
2.6.	Алслагдсан баг, хороо болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үйлчилгээ үзүүлэх боломжийг бүрдүүлж зөөврийн интернэт сүлжээг бий болгох ажлыг зохион байгуулах	Үйл ажиллагаа	Зөөврийн интернет сүлжээгээр хангагдсан сумдын тоо	4	9	Тус аймгийн 14 сумын улсын бүртгэгч нараас 4 суманд зөөврийн 4G төхөөрөмж хэрэглэгддэг бөгөөд зөөврийн интернэт сүлжээний төхөөрөмжгүй 10 сумдыг төхөөрөмжөөр хангах асуудлаар аймгийн ИТХ-ын дарга Н.Алдарбаяртай уулзалт зохион байгуулсан. Мөн Айраг, Дэлгэрэх, Иххэт сум, Замын-Үүд, Хатанбулаг суманд ажиллах үеэр сумдын Засаг дарга нарт зөөврийн төхөөрөмжийн хэрэглээ ач холбогдлыг танилцуулсан бөгөөд Иххэт, Хатанбулаг сумдын удирдлагууд зөөврийн төхөөрөмжийг төсөвийг шийдвэрлэн худалдан авалт хийгээд байна. Тус төхөөрөмжүүдэд шаардлагатай тохиргоог хийлгэхээр УБЕГ-т 2025 оны 18/977 дугаартай албан бичгийг хүргүүлсэн.	90%
2.7	Хууль хяналтын болон төрийн байгууллага, иргэн, хуулийн этгээдэд эд хөрөнгийн	Үйл ажиллагаа	Хууль хяналтын болон төрийн байгууллага, иргэн хуулийн	10	15	Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй хууль хяналтын байгууллага (Авилгатай тэмцэх газар, Цагдаагийн газар болон Сум дундын анхан шатны шүүх, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар)-д нийт 856	100%

	эрхийн улсын бүртгэлтэй холбоотой мэдээлэл, лавлагаа өгөх, нотлох баримтын хуулбар хүргүүлэх		этгээдээс лавлагаа мэдээлэл, нотлох баримтын хуулбараар үйлчилсэн үйлчилгээний тоо			лавлагаа, 29 нотлох баримтыг хуулбарлан нийт 885 удаа үйчилгээ үзүүлсэн байна.	
2.8.	Улсын бүртгэлийн үйлчилгээний цахим машин (Киоск)-ийн тоог нэмэгдүүлж, киоскоор үзүүлэх улсын бүртгэлийн үйлчилгээ, хүртээмжийг нэмэгдүүлэх	Үйл ажиллагаа	Улсын бүртгэлийн үйлчилгээний цахим машин /Киоск/-ны нэмэгдүүлсэн тоо	2	2	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам, Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар, “Гэрэгэ Киоск” ХХК хамтран сумдын хэрэгцээ шаардлагад үндэслэн цахим киоск машиныг хувиарлах арга хэмжээнд хамтран ажиллаж киоск төхөөрөмжгүй судмын судалгааг гарган аймгийн хэмжээнд 2025 оны 07 дугаар сард 12 суманд цахим үйлчилгээний киоск машиныг байршуулсан.	100%
2.9.	Улсын бүртгэлийн үйлчилгээг зөөврийн тоног төхөөрөмж ашиглан үзүүлэх боломжийг бүрдүүлж тоног төхөөрмжийг хэрэглээнд нэвтрүүлэх	Орон нутгийн төсөв	Хэрэглээнд нэвтэрсэн хөдөлгөөнт төхөөрөмжийн тоо.	0	1	Зөөврийн тоног төхөөрөмжийн үнийн судалгааг гаргаж аймгийн удирдлагуудад танилцуулсан бөгөөд шаардлагатай төсөв болох 275.6 сая төгрөгийг орон нутгийн төсөвт тусгуулахаар аймгийн ИТХ-ын дарга Н.Алдарбаярт 2025 оны 18/78 дугаартай албан бичгээр саналаа хүргүүлсэн. Мөн зөөврийн тоног төхөөрөмжөөр үйлчилгээ үзүүлэх нөхцөлийг бүрдүүлж Айраг суманд зөөврийн компьютер, Дэлгэрэх сум зөөврийн компьютер, Иххэт суманд 4G зөөврийн компьютер, Замын-Үүд 4G, зөөврийн компьютер, Хатанбулаг 4G төхөөрөмжийг тус тус шийдвэрлэн ажилласан.	100%

2.10	Улсын бүртгэлийн хэлтсийн 2025 оны үйл ажиллагаанд эрсдлийн үнэлгээ хийх	Үйл ажиллагаа	Эрсдлийн үнэлгээний батлагдсан төлөвлөгөөний тоо	1	1	Эрсдэлийг бууруулах 4 зорилтын 7 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөгөөг боловсруулан батлуулж хэрэгжилтийг ханган ажилласан.	90%
		Үйл ажиллагаа	Эрсдэл бууруулсан хувь	75%	90%	Эрсдэл бууруулах төлөвлөгөөний дагуу дараах ажил хийгдсэн. Үүнд: -УБЕГ-ын 2025 оны “Аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн зохион байгуулалтын бүтэц, орон тоо, ангилал, зэрэглэлийг шинэчлэн батлах тухай” А/157 дугаар тушаал гарсаны дагуу хэлтсийн бүтэц, орон тоонд багтаан ТҮ-ний албан хаагчдыг ажиллуулж стратегийн эрсдэлийг бууруулсан. -Мөн гадаад паспортыг сумын иргэдэд эрсдэлгүй, аюулгүй, шуурхай хүргэх зорилгоор “Монгол шуудан”-гийн Дорноговь аймаг дахь салбартай гэрээ байгуулан “Дотоодын энгийн шуудан үйлчилгээ”-ний хамгийн бага тариф болох 4650 төгрөгөөр хүргэлтийн үйлчилгээг үзүүлсэн. -Байгууллагад ашиглагдаж байгаа 21 компьютерт лицензтэй вирусын програм суулгаснаар гадны халдлагад өртөх эрсдлийг бууруулсан. -Сангийн яамнаас батлагдсан төсвийн дагуу санхүүжилтээс 12 дугаар сард олгохоор 3 удаа татсан. -Ахмадын сангийн данс нээлгэх хүсэлтийг аймгийн Санхүү төрийн сангийн хэлтсээр дамжуулан Сангийн Яаманд хүргүүлсэн. -Байгууллагын 2025 оны төсвийг бодитой төлөвлөснаар өр үүсгэлгүй ажиллаж	

						санхүүгийн эрсдэлгүй ажилласан. -Хэлтсийн даргын 2025 оны “Ажлын хэсэг байгуулах тухай” А/17 дугаар тушаалаар төрийн үйлчилгээг иргэдэд стандартын шаардлага хангасан заал, танхимаар үйлчилгээ үзүүлэх зорилгоор Сайншанд сумын хэмжээнд ажлын байрны судалгаа явуулж “Саруул талын өргөө” ХХК-ийн оффисын зорилулттай барилгад 450м2 талбайг ашиглахаар шийдвэрлэсэн. -Албан хаагчдын ажлын цаг ашиглалтыг сайжруулах, эрүүл мэнд, ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх зорилгоор тус хэлтсийн даргын 2025 оны 07 дугаар сарын 31-ний өдрийн А/15 дугаар тушаалаар ажиллах цагийг хуваарийг шинэчилснээр нийцлэлийн эрсдлийг тус тус бууруулсан.	
2.11.	Хэрэглэгчийн үнэлгээ хийх ажлыг зохион байгуулах	Үйл ажиллагаа	Хэрэглэгчийн үнэлгээ хийлгэсэн тоо	1	1	Хэрэглэгчийн үнэлгээ хийх ажлыг зохион байгуулж 274 иргэнээс сэтгэл ханамжийн судалгаа авч үнэлгээг тогтоосон. Улсын бүртгэлийн үйлчилгээний чанар хүртээмжийн асуулгад 99.6% хүссэн үйлчилгээгээ авч чадсан байх бөгөөд Иргэний улсын бүртгэлийн чиглэлээр-79.9%, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл-15%, хуулийн этгээдийн улсын бүртгэл-5.1% тус тус үйлчилгээ авсан байна. Албан хаагчын ажлын ачаалал 93.8% дүгнэгдсэн бол Улсын бүртгэлийн ажилтны харилцаа, хандлага ёс зүй, мэргэжлийн ур чадварыг 91.9% гэж үнэлгээ өгсөн байна. Мөн Манай байгууллагын үйл ажиллагааг сайжруулахад ямар ажил арга хэмжээ зохион байгуулвал үр дүнтэй байх талаар санал авахад:	100%

						-Үйлчилгээний стандартад нийцсэн байртай болох, Ажлын оффис шинээр бий болгох, Нээлттэй хаалганы өдөрлөг тогтмол зохион байгуулах, зөөврийн тоног төхөөрөмжийн үйлчилгээг хүргэх, сүлжээ удаашралтай, сүлжээний хурдыг нэмэгдүүлэх, хяналтын улсын байцаагчийн орон тоог нэмэгдүүлэх, ханги хилийн боомтод тогтмол ирж ажиллах зэрэг санал хүсэлтүүдийг ирүүлсэн байна.	
2.12.	Улсын бүртгэлийн багц хуулийн нэмэлт өөрчлөлтийн төсөлд санал хүргүүлэх	Үйл ажиллагаа	Хүргүүлсэн саналын тоо	2	3	Тус арга хэмжээний хүрээнд дараах эрх зүйн баримт бичигт санал хүргүүлсэн байна. Үүнд: - Иргэний улсын бүртгэлийн тухай хуульд гэрлэлт дуусгавар болсны бүртгэл, эцэг эхийн овог өөрийн нэр солих бүртгэл, - Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хууль болон Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль, - Хуулийн этгээдийн нэр баталгаажуулах журам, - Хуулийн этгээд, түүний салбар төлөөлөгчийн газрын улсын бүртгэл хөтлөх журам, - Тамга тэмдэг хийлгэх, үйл ажиллагаанд хяналт тавих, лавлагаа олгох журам, - Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл - Улсын бүртгэлийн ерөнхий хууль, иргэний улсын бүртгэлийн тухай хууль, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хууль, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулиудад хяналтын байцаагчийн чиг	100%

						үүрэгтэй холбоотой саналыг холбогдох газруудад тус тус хүргүүлсэн.	
2.13.	Орон нутгийн хэмжээнд төрийн эрх бүхий байгууллагын шийдвэрээр хуулийн этгээдийн бүртгэлд хориг тавих, цуцлах арга хэмжээг хэрэгжүүлэх	Үйл ажиллагаа	Хуулийн этгээдийн улсын бүртгэлд хориг тавьсан болон цуцалсан тоо	5	6	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын шийдвэр гүйцэтгэгчийн тогтоол, шийдвэрээр 16 хуулийн этгээдийн улсын бүртгэлд хориг тавих, цуцлах тухай шийдвэр ирснийг тухай бүр мэдээллийн санд тусгаж ажилласан.	100%
2.14	Орон нутгийн хэмжээнд бүртгэсэн иргэний улсын бүртгэлийн нэмэлт өөрчлөлт оруулах, засварлах, нөхөн бүртгэх арга хэмжээг хэрэгжүүлэх	Үйл ажиллагаа	Нэмэлт өөрчлөлт оруулах, засварлах, нөхөн бүртгэх бүртгэлийн тоо	251	154	УБЕГ-ын архивын газраас ирүүлсэн 1078 алдаатай бүртгэлийг алдааг мэдээллийн сан болон цахим архивын санд тулган шалгалт хийж хувийн хэрэг эх нотлох баримтыг үндэслэн 1067 алдаа засварласан. Иргэний улсын бүртгэлийн үндсэн санд нэрийн галиг, гэрлэлтийн байдлын төлөвт алдаатай бүртгэгдсэн 77 иргэний хүсэлтийг хүлээн авч мэдээллийн санд засварласан. Тус хэлтэс нь Улсын бүртгэлийн байгууллага үүсч хөгжсөний 85 жилийн ойн хүрээнд Дорноговь аймгийн 14 сумын хэмжээнд иргэний бүртгэлийн мэдээллийн сангийн цахимжуулалтыг нэмэгдүүлэх, бүртгэлийн үнэн зөв байдлыг хангах, сумдын улсын бүртгэгч нарын үйл ажиллагааг идэвхижүүлэхээр “Иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санг цэгцлэх, нөхөн бүртгэл хийх” уралдааныг зарлаж цахимжуулаагүй болон программын хөрвүүлэлтээс шалтгаалан мэдээлэл дутуу, алдаатай бүртгэгдсэн мэдээллийг засах, 1951-1988	100%

						оны төрсний, гэрлэсний, гэрлэлт дуусгавар болсны, эцэг /эх/ тогтоосны, үрчилсний, овог нэр, өөрийн нэр өөрчилсний, нас барсны бүртгэлийг нөхөн бичиж иргэний улсын системд бүртгэх ажлын хүрээнд эх нотлох баримт бичиг, иргэний улсын бүртгэлийн маягтыг үндэслэн төрсний бүртгэл-150, гэрлэлтийн бүртгэл-13, нас барсны бүртгэл-1, нийт 164 бүртгэлийг иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санд шивж баталгаажуулсан.	
ЗОРИЛТ 3.УЛСЫН БҮРТГЭЛИЙН МЭДЭЭЛЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, НЭГДСЭН САНГИЙН НУУЦЛАЛЫГ ХАНГАН, ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫГ ХЭРЭГЖҮҮЛНЭ.							
3.1.	Эд хөрөнгө, хуулийн этгээд, иргэний улсын бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх	Үйл ажиллагаа	Хяналт шалгалтын тоо	3	6	Бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх төлөвлөгөө боловсруулан хэлтсийн даргаар батлуулж, төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу эхний хагас жилд хийж гүйцэтгэх ажлуудыг бүрэн дуусгасан. Өргөдөл, санал гомдлын мөрөөр 61 удаа, төлөвлөгөөт хяналт шалгалтыг 4 удаа нийт 65 удаагийн хяналт шалгалтыг хийсэн. Өдөр дутмын болон урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг тогтмол хийж иргэний улсын бүртгэлийн чиглэлээр 2151, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр 239, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр 42 нийт 2432 бүртгэлд хяналт шалгалт хийж 162 зөрчил илрүүлж арилгуулах арга хэмжээ авч ажилласан байна.	100%
3.2.	Эд хөрөнгө, хуулийн этгээд, иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санг цэгцлэх арга хэмжээг зохион	Үйл ажиллагаа	Эд хөрөнгө, хуулийн этгээд, иргэний улсын бүртгэлийн	2%	5%	Иргэн болон эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн мэдээллийн санг цэгцлэхээр УБЕГ-ын Мэдээллийн технологийн газрын дарга Б.Анхбаярт аймгийн хэмжээнд 1988-2011 онд нас барсан иргэдийн мэдээлэл, аймгийн хэмжээнд иргэнд өмчилсөн газрын	90%

	байгуулах		мэдээллийн санг цэгцэлсэн хувь			мэдээллийн баазыг цахим хэлбэрээр авах тухай 2025 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн 18/329 дугаар албан бичиг хүргүүлж ирүүлсэн мэдээллийн дагуу нэгдсэн байдлаар дүн шинжилгээ хийж шаардлагатай засварыг гүйцэтгэсэн бөгөөд 1367 архивын эх нотлох баримтыг эрхийн улсын бүртгэлийн мэдээллийн сантай тулган шалгаж хувийн хэрэгт хадгалагдаж байгаа тусгаарласан баримтыг ангилан ялгалт хийж архивын хадгаламжийн нэгж болгосон цэгцэлсэн.	
3.3.	Улсын бүртгэлийн хэлтсийн компьютер, түүний дагалдах техник, тоног төхөөрөмжийг үе шаттайгаар шинэчлэх, сайжруулах	Үйл ажиллагаа	Шинэчлэгдсэн техник, тоног төхөөрөмжийн тоо	5	8	Тус хэлтсийн албан хаагчид УБЕГ-т 2025 оны 10 дугаар сарын 03-ны өдөр ажилласан бөгөөд энэ үеэр газрын даргын шийдвэрээр иж бүрэн компьютер-1, зөөврийн компьютер 3, принтрийн асуудлыг шийдвэрлэж өгсөний дагуу хэлсийн албан хаагчдын техник, тоног төхөөрөмжийг шинэчилсэн. Мөн Замын-Үүд суманд 2025 оны 9 дүгээр сарын 11-нд ажиллах үеэр тус сумын улсын бүртгэгчид түргэн скайнерийг гардуулан өгч шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангаж ажилласан. Иххэт, Хатанбулаг сумдад Зөөврийн интернэт сүлжээний төхөөрөмжийг орон нутгийн төсвөөр шийдвэрлүүлж худалдан авалт хийгдсэн.	100%
3.4.	Серверийн өрөөний тоног төхөөрөмж, дагалдах хэрэгсэлд засвар үйлчилгээ хийх	Үйл ажиллагаа	Серверийн өрөөний тоног төхөөрөмжид засвар үйлчилгээ хийсэн тоо	0	1	Серверийн өрөөний тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагааг хангах ажлын хүрээнд 2025 оны 10 дугаар сарын 22-23-ны өдрүүдэд өмнө нь ашиглаж байсан дотоод сүлжээний рөүтерийг fortinet рөүтэр төхөөрөмжөөр сольж тохиргоо хийлгэн шинэчилсэн.	100%

3.5.	Архивын баримтын хадгалалт хамгаалалтын нөхцөлийг сайжруулах	Үйл ажиллагаа	Хадгалалт хамгаалалтын хэвийн үйл ажиллагааг ханган ажилласан хувь	75%	95%	Байгууллагын архивын баримтыг “Гамшгийн үед нүүлгэн шилжүүлэх ажлын төлөвлөгөө” боловсруулж батлуулан мөрдөж ажилласан. Ажил гүйцэтгэх үеийн ажлын байрны аюулгүй ажиллагааны дагуу ажлын ширээ, сандалны бүрэн бүтэн байдал, компьютер, принтер зэрэг цахилгаан хэрэгслийн хэвийн ажиллагаа, галын аюулгүй байдал зэргийг тухай бүр шалган шаардлагатай арга хэмжээг авч ажилласан. Архивчийн ажлын байранд тохирсон багаж хэрэгсэл болох маск, гар ариутгагч, нэг удаагийн бээлий, хуруувч зэрэг хамгаалах хэрэгслийг сар бүр олгодог бөгөөд чийг дулаан хэмжигч, зөөврийн шат, 2 агааржуулах төхөөрөмжийг тогтмол ажиллуулж байна.	100%
		Үйл ажиллагаа	Архивт шүүгээ нэмэгдүүлсэн тоо	0	5	Архивын баримтын хадгалалт хамгаалалтын нөхцөлийг сайжруулах зорилгоор Нийслэлийн Улсын бүртгэлийн газар татан буугдсантай холбогдуулан тус газраас угсармал 7, ханын үргэлжилсэн 7, нийт 14 тавиурыг шийдвэрлүүлж архивын шүүгээг нэмэгдүүлсэн.	100%
3.6.	Хуулийн этгээдийн мэдээллийн санг цэгцлэх зорилгоор төрийн эрх бүхий байгууллагуудтай хамтран төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн зөрчлийг арилгах ажлыг зохион байгуулах	Үйл ажиллагаа	Зөрчил арилгасан хувь	1	3	Төрийн байгууллагуудын удирдлагын өөрчлөлтийг хуулийн хугацаанд бүртгүүлсэн эсэхэд хяналт тавьж зөрчлийг арилгасан. Үүнд: - Зэвсэгт хүчний 336 анги, - Өргөн сумын соёл, спортын төв, - Замын-үүд сумын ЗДТГ, - Улаанбадрах сумын ЭМТ, - Дэлгэрэх сумын ЗДТГ, - Хатанбулаг сумын ЕБС, - Алтан ширээ сумын ЭМТ, - Сайншанд сумын ЗДТГ-ын зөрчлийг	100%

						хяналтын улсын байцаагчаар зөрчил хянан шийдвэрлүүлж зөрчлийг арилгасан. Мөн хуулийн этгээдийн улсын бүртгэлийн сан болон аймгийн Татварын газрын мэдээллийн санд регистрийн дугаар зөрүүтэй 2 хуулийн этгээдийн мэдээллийг шалгуулан зөрчлийг шийдвэрлэн Татварын газарт хариуг хүргүүлсэн.	
3.7.	Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах	Үйл ажиллагаа	Тайлагнаж, байршуулсан мэдээллийн тоо	828	830	Шилэн дансны тухай хуулийн дагуу 2025 оны жилийн эцсийн байдлаар төлөвлөгөөний дагуу 143 төрлийн 596 мэдээллийг хугацаанд нь байршуулсан.	100%
3.8.	Эцсийн өмчлөгчийн мэдээллийн үнэн зөв байдлыг хангах, чанарыг сайжруулах ажлыг зохион байгуулах	Үйл ажиллагаа	Эцсийн өмчлөгчийн мэдээлэл бүртгэгдсэн тоо	0	10	Хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгүүлэх хуулийн зохицуулалтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд эцсийн өмчлөгчийн мэдээллээ бүртгүүлээгүй “Алтанбаян буурал” ХХК, “Гоё мөрөн” ХХК, “Марал шанд” ХХК, “Энхномин говь” ХХК, “Гурван баян ширээ” ХХК “АЕ ложистик” ХХК, “Ерөөлт буян дэлгэрэх” ХХК “Зам-Орчин” ТББ, Энкура ХХК, Бүрэн торх ХХК, Хуш нарсан ойн төгөл Хоршоо гэсэн 11 хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийн мэдээллийг бүртгэсэн. Тус хэлтэс нь аймгийн хэмжээнд бүртгэлтэй хуулийн этгээдийн мэдээлэлд хяналт шалгалт хийж эцсийн өмчлөгчийн мэдээллийн үнэн зөв байдлыг хангах, мэдээллийн санг цэгцлэх ажлыг зохион байгуулж эцсийн өмчлөгчийн мэдээллээ бүртгүүлээгүй, одоо үйл ажиллагаа явуулж байгаа эсэх нь тодорхойгүй 300 хуулийн этгээдийн судалгааг гаргаж татвар төлөгчөөр бүртгэлтэй буюу тайлангаа илгээдэг эсэх, татварын нэгдсэн системд бүртгэлтэй эсэхийг тодруулахаар Дорноговь аймгийн	100%

						Татварын газарт 2025 оны 18/979 дугаар албан бичиг хүргүүлэн ажилласан.	
ЗОРИЛТ 4. ХАМТЫН АЖИЛЛАГААГ ӨРГӨЖҮҮЛЭХ, ТӨРИЙН БОЛОН ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГУУДЫН УЯЛДАА ХОЛБООГ САЙЖРУУЛАХ							
4.1.	Алслагдмал бүс нутгуудад төрийн үйл ажиллагаа явуулж байгаа хилийн цэргийн анги болон бусад хил хамгаалах чиг үүргийн болоод хилийн бүсэд үйл ажиллагаа явуулж буй төрийн байгууллагууд, тэдгээрийн ажилтан, алба хаагчдад улсын бүртгэлийн үйлчилгээг түргэн шуурхай үзүүлэх	Үйл ажиллагаа	Төрийн байгууллага хоорондын харилцааг сайжруулах, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх эр зохион байгуулсан арга хэмжээний тоо	1	2	Алслагдсан бүс нутагт ажиллаж, амьдарч буй иргэн, хуулийн этгээдэд бүртгэлийн үйлчилгээг түргэн, шуурхай хүргэх зорилгоор 2025 оны 09 дүгээр сарын 11-ний өдөр Замын-Үүд сумын Замын-Үүд боомтод, 2025 оны 10 дугаар сарын 09-ний өдөр Хатанбулаг сумын Ханги боомтод тус тус ажилласан. Мөн улсын бүртгэлийн үйлчилгээний хураамжийг Гэрэгэ посс машинаар төвлөрүүлэн ажилласан бөгөөд олон удаагийн хавсралтад ашиглах цээж зургийг тухай бүр авч улсын бүртгэлийн үйлчилгээг шуурхай хүргэн ажиллалаа.	100%
4.2.	Хил орчимд уул уурхай, тээвэр ложистикийн үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгж байгууллагын ажилчид, тээвэрчид, хил орчимд оршин суух туслах хүчний үүрэг бүхий малчин иргэдэд улсын бүртгэлийн үйлчилгээг түргэн шуурхай үзүүлэх	Үйл ажиллагаа	Төрийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх эр зохион байгуулсан арга хэмжээний тоо	1	2	Тус ажлын хүрээнд Хатанбулаг суманд гадаад паспортын захиалгын үйлчилгээг анхлан нэвтрүүлж тухайн суманд үйл ажиллагаа явуулж буй Хангимандал боомт орчмын уул уурхай, тээвэр ложистикийн үйл ажиллагаа явуулж буй ААНБ-ын албан хаагчдад 38 гадаад паспортын захилга авч бүртгэлийн үйлчилгээг түргэн шуурхай үзүүлсэн. Замын-Үүд суманд 2025.09.11-ний өдөр “Танд ойрхон төрийн үйлчилгээ” хэрэгжүүлэхэд нийт 113 иргэн, 7 хуулийн этгээдэд улсын бүртгэлийн үйлчилгээ мөн 2025.10.09-ний өдөр Хатанбулаг сумын Ханги боомтод “Танд ойрхон төрийн үйлчилгээ” арга хэмжээг хэрэгжүүлэхэд уул уурхайн	100%

						тээвэр ложистик эрхэлдэг “Мөнх шижир алт” ХХК, “Номт даншиг” ХХК, “Дорнын өртөө” ХХК тэдгээрийн 8 ажилтан, 3 малчин, 16 иргэнд улсын бүртгэлийн үйлчилгээг үзүүлсэн байна.	
4.3.	“Шинэ Хоршоо” хөдөлгөөн, бичил уул уурхайн нөхөрлөлүүдийг дэмжих зорилгоор малчид болон мал бүхий иргэд, бизнес эрхлэгчид, бусад чиг үүргийн хувийн хэвшлийн байгууллагуудтай олон талт хамтын ажиллагааг явуулах	Үйл ажиллагаа	Хоршоо, нөхөрлөл бусад хувийн хэвшлийн байгууллагуу дтай хамтран гүйцэтгэсэн арга хэмжээний тоо	1	2	“Шинэ хоршоо” хөдөлгөөн хүрээнд аймгийн хэмжээнд нийт 249 хоршоо байгуулагдаж шинээр бүртгэсэн. Мөн шинээр 21 бичил уурхайн нөхөрлөл байгуулагдсаныг хууль журмын дагуу хуулийн этгээдийн бүртгэлд бүргэсэн. Сумын ЗДТГ болон Хүнс хөдөө аж ахуйн газрын мэргэжилтэн нартай хамтран ажиллаж “Малчдын нэгдсэн зөвлөгөөн”-д оролцож бичил уурхайн нөхөрлөл, хоршоо, малчид болон бизнес эрхлэгч нарт улсын бүртгэлийн үйлчилгээний талаар зөвлөгөө мэдээллээр хангаж, Шинэ хоршоо хөдөлгөөнийг сурталчилан 679 гарын авлага хүргүүлж хамтран ажилласан.	100%
4.4.	Төрийн бус байгууллагуудын 2024 оны үйл ажиллагааны тайланг хүлээн авах	Үйл ажиллагаа	Тайлан хүлээн авсан тоо	30	36	Тайлант хугацаанд 37 хуулийн этгээдийн 2024 оны үйл ажиллагааны тайланг хүлээн авсан.	100%
4.5.	Орон нутгийн хэмжээнд санхүүгийн тайланг 8 ба түүнээс дээш улирал дараалан гаргаагүй, харилцагч санхүүгийн байгууллагад илгээж баталгаажуулаагүй, шинэчилсэн бүртгэлд хамрагдаагүй	Үйл ажиллагаа	Улсын бүртгэлээс хасагдсан хуулийн этгээдийн тоо	0	50	Сангийн яамнаас санхүүгийн тайланг 8 ба түүнээс дээш улирал дараалан гаргаагүй, харилцагч санхүүгийн байгууллагад тайлан илгээж баталгаажуулаагүй тус аймагт бүртгэлтэй 235 хуулийн этгээдийн мэдээллийг Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсэгт заасны дагуу www.burtgel.gov.mn цахим хуудаст байршуулсныг байгууллагын цахим хуудсаар нийтэд мэдээлсэн. Үүнээс хасагдах жагсаалтад орсон 157 хуулийн этгээдэд	

	хуулийн этгээдийг Сангийн яамны саналыг үндэслэн хуульд заасан хугацаанд улсын бүртгэлээс хасах ажлыг зохион байгуулах					урьдчилан мэдэгдэж 10 хуулийн этгээд уг жагсаалтаас чөлөөлөх хүсэлт ирүүлснийг хүлээн авч хуулийн этгээдийн улсын бүртгэлийн мэдээллийн санд цахимжуулсан.	
--	---	--	--	--	--	--	--

ЗОРИЛТ 5. АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР ХЭРЭГЖҮҮЛНЭ

5.1.	Улсын бүртгэлийн хэлтсийн 2025 оны Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан батлуулах, хэрэгжилтийг хангаж ажиллах	Үйл ажиллагаа	Хэрэгжилтийг хангасан хувь	1	1	Авлигатай тэмцэх үйл ажиллагааны хөтөлбөрийг 2025 оны 03 дугаар сарын 28-ны өдөр боловсруулан баталгаажуулж хэрэгжилтэнд хяналт тавьж ажилласан.	100%
5.2.	Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх	Үйл ажиллагаа	АТГ-аас бэлтгэсэн тв шторк, инфографик, видео график, нийтлэл, теле зохиомж, хөдөлгөөнт зураг, зурагт хуудас, цахим ном, гарын авлага зэргийг албан ёсны цахим хуудас болон нийгмийн	-	5	УБЕГ-ын Иргэний улсын бүртгэлийн газраас “Мөрдөгчийн мэдэгдэл хүргүүлэх тухай” 2025 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн 3/8699 дугаар албан бичиг ирүүлсний дагуу хэлтсийн албан хаагч нарт танхимаар, сумдын улсын бүртгэгч нарт цахимаар (zoom) хурал хийж Авлигатай тэмцэх газрын Мөрдөн шалгах хэлтсийн 2025 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн 90 дугаартай мөрдөгчийн мэдэгдлийг танилцуулж, хяналтын улсын байцаагч, улсын ахлах бүртгэгч нарт Улсын бүртгэлийн үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулахыг үүрэг болгосон. Мөн иргэний мэдээллийн цахим системд тухайн иргэнийг өөрийн биеэр хүрэлцэн ирээгүй тохиолдолд аливаа төрлийн бүртгэл хийхгүй байх, зөвхөн хурууны хээ уншуулж улсын бүртгэл	100%

			сүлжээ, мэдээллийн самбарт байршуулж, олон нийтэд хүргэсэн тоо		хөтлөхийг улсын бүртгэгч нарт анхааруулж, сануулга өгч, гэмт хэрэг гарахаас урьдчилан сэргийлэх чиглэлээр, сурталчилгааны материал тараах арга хэмжээ авч ажиллахыг улсын ахлах бүртгэгч нарт үүрэг, чиглэл өгч ажиллаласан. Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах ажлын хүрээнд “АВИЛГА, АШИГ СОНИРХОЛГҮЙ ХАМТ ОЛОН” шторкыг бэлтгэн хэлтсийн фэйж хуудас болон цахим хуудсанд байршуулан олон нийтийн сувгаар мэдээлсэн Мөн өрөө бүрт Авлигатай тэмцэх газраас эрхлэн гаргасан “Нэгдье” зурагт хуудсыг байршуулж урьдчилан сэргийлэх сурталчилгаа, соён гэгээрүүлэх арга хэмжээний хүрээнд зохион байгуулсан. Мөн дараах зурагт хуудсыг үйлчилгээний заал болон мэдээллийн самбарт байршуулсан. Үүнд: - “Иргэн та бүртгэлийн үйлчилгээний хураамжийг зөвхөн банк болон Гэрэгэ киоск машинд тушаах”, - “Манай үйлчилгээнд яаралтай бүртгэлийн хураамж байхгүй болохыг танд мэдэгдэж байна”, - Бид авилга авахгүй, та авилга өгөх хэрэггүй, бид танд үйлчлэх үүрэгтэй” - “Иргэн танд ёсзүйн зөрчлийн талаарх гомдол, мэдээлэл байвал бичгээр хандана уу” - Барел үсгээр Иргэн та дараах тохиолдолд АТГ-т хандах боломжтой, - АТГ-ын мэдээлэл хүлээн авах 110 дугаар зэргийн мэдээллийг агуулсан	
--	--	--	--	--	---	--

						хуудсыг байршуулсан	
5.3.	Улсын бүртгэлийн хэлтсийн албан хаагчдын ХАСХОМ-ыг хуулийн хугацаанд мэдүүлэх	Үйл ажиллагаа	ХАСХОМ мэдүүлсэн албан хаагчийн тоо	24	25	УБЕГ-аас зохион байгуулсан ХАСХОМ гаргахад анхаарах асуудал сэдвээр сургалтад хэлтсийн 26 албан хаагч хамрагдаж 2024 оны ХАСХОМ-ийг зааврын дагуу гаргсан. ХАСХОМ-1, ХАСХОМ хураангуй, ХАС-ын хураангуй тайланг УБЕГ-ын Тамгын газрын хариуцсан ажилтны албан мэйлээр илгээсэн.	100%
ЗОРИЛТ 6. ЧАДАХУЙН ЗАРЧИМД СУУРИЛСАН ХҮНИЙ НӨӨЦИЙГ БҮРДҮҮЛЖ, АЛБАН ХААГЧДЫН НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАНА.							
6.1.	Хэлтсийн 2025 онд зохион байгуулах сургалтын төлөвлөгөөг боловсруулж батлуулах, хэрэгжилтийг хангаж ажиллах	Үйл ажиллагаа	Сургалтын төлөвлөгөөний биелэлтийн хувь	98%	100%	Хэлтсийн сургалтын төлөвлөгөөг боловсруулсан бөгөөд нийт 16 арга хэмжээг төлөвлөн хэрэгжилтийг ханган ажилласан. Сургалтын төлөвлөгөөний дагуу Удирдлагын академийн дунд хугацааны сургалтад Замын-Үүд сумын улсын бүртгэгч Б.Мөнх-Учрал хамрагдсан. Удирдлагын академийн ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтанд хамрагдах тухай 2 албан хаагчийн хүсэлтийг УБЕГ-ын Эрх зүйн сургалтын хэлтэст, Сайншанд сумын улсын бүртгэгч	100%

						Ө.Сонинбаяр нь Удирдлагын академийн Төрийн албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны сургалтад хувийн зардлаар суралцах тухай хүсэлтийг аймгийн ЗДТГ-т тус тус хүргүүлсэн. Мөн КОИКО төслөөс 2025 оны 06 дугаар сарын 1--14-нийг хүртэлх хугацаанд зохион байгуулсан Монгол Улсын үндэсний бүртгэлийн системийн Дижитал чадамжийг бэхжүүлэх хөтөлбөрт хэлтсийн дарга С.Энх-Эрдэнэ хамрагдсан. Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 01 албан даалгавар, 03 албан даалгаврын дагуу төрийн албаны сахилга, хариуцлага, дэг журмыг өндөржүүлэн ажлын бүтээмжийг сайжруулах зорилгоор Улсын бүртгэлийн хэлтсийн ажилтан албан хаагч, бүртгэгч нарын хамтын ажиллагааг нэмэгдүүлэх, чадавхижуулах сургалтыг 2025 оны 04 сарын 10-ны өдөр зохион байгуулсана. Мөн Улсын бүртгэлийн хэлтсийн даргын санаачилгаар хойд болон өмнөд бүсийн сумдын сургалтыг 2025 оны 07 сарын 04-нд Иххэт суманд, 2025 оны 09 сарын 11-нд Замын-Үүд суманд тус тус зохион байгуулсан.	
--	--	--	--	--	--	--	--

6.2.	Улсын бүртгэлийн хэлтсийн “Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах үйл ажиллагааны төлөвлөгөө”-г боловсруулж батлуулах, хэрэгжилтийг хангаж ажиллах	Үйл ажиллагаа	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	50%	100%	“Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг дараах байдлаар ханган ажилласан. Үүнд: -2025 оны 04 дүгээр сарын 09-11-ний өдрүүдэд улсын бүртгэгч нарыг мэргэшүүлэх нэгдсэн сургалт зохион байгуулж сургалтын зардалд 300,000 төгрөг зарцуулсан. -Удирдлагын академийн дунд хугацааны сургалтад Замын-Үүд сумын улсын бүртгэгч, мөн Удирдлагын академийн Ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтанд хамрагдах тухай 2 албан хаагчийн хүсэлтийг Эрхзүйн сургалтын хэлтэст хүргүүлсэн. -УБЕГ-ын даргын 2025 оны “Сургалт зохион байгуулах тухай” А/172 дугаар тушаалын дагуу төрийн захиргааны албан тушаалд шинээр томилогдсон албан хаагчдыг чиглүүлэх, дадлагажуулах сургалтанд хэлтсийн дарга С.Энх-Эрдэнэ нь хамрагдсан. -УБЕГ-ын даргын Б/458 дугаар тушаалаар төрийн албан хаагчид шинээр зэрэг дэв олгосон 1, зэрэг дэвийг 8 албан хаагчид ахиулан олгосон. -Хэлтсийн нийт албан хаагчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт 2 удаа хамруулсан. -УБЕГ-ын даргын шийдвэрлэсэн иж бүрэн компьютер-1, зөөврийн 3 компьютер, принтрийг хэлтсийн албан хаагчдад хувиарлан ажилласан. -Хэлтсийн албан хаагчдад төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл болон сар бүр унаа, хоолны мөнгө, орон нутгийн нэмэгдэл,	100%
------	--	---------------	---------------------------------	-----	------	---	------

						төрийн үйлчилгээний албан хаагчдад ур чадварын нэмэгдлийг үндсэн цалин дээр нэмж олгосон. Улсын бүртгэлийн байгууллагын “Хөдөлмөрийн дотоод журам”-ын 8.15.2-д заасны улсын бүртгэгч нас барахад ар гэрт нь 1 удаагийн буцалтгүй мөнгөн тусламж, хэлтсийн албан хаагчдын хуримтлалын сангаас ар гэрт гачигдал тохиолдсон, 6 албан хаагчийн гэр бүлд нь нийт 4,380,000 төгрөгийн тусламж үзүүлсэн байна. Сайншанд хотод үйл ажиллагаа явуулдаг барилгын компаниудын удирдлагуудтай уулзалт хийж Энержи парагон ХХК-ийн 2025 оны 3 дугаар улиралд ашиглалтанд орсон орон сууцнаас 1 албан хаагчид хөнгөлөлттэй үнээр, мөн Гантулга трейд ХХК-ийн Мандах наран хорооллын төрийн албан хаагчийн түрээсийн орон сууцанд 1 албан хаагчийг тус тус хамруулж нийгмийн баталгааг ханган ажилласан.	
6.3.	Монгол хэлний тухай хууль, Засгийн газрын 2020 оны 96 дугаар тогтоолын хэрэгжилтийг ханган албан хэргийг кирилл болон үндэсний хос бичгээр хөтлөх арга хэмжээг хэрэгжүүлэх	Үйл ажиллагаа	Албан хэргийг кирилл болон үндэсний хос бичгээр хөтөлсөн хувь	-	100%	Төрийн байгууллага албан хэрэг хөтлөлтийн явцад үүссэж буй баримт бичгийг 2025 оноос эхлэн хос бичгээр үйлдэнэ гэсний дагуу 2025 оны 10 дугаар сарын байдлаар 624 албан бичгийг “Монгол бичгээр үйлдэх баримт бичгийн хэвлэмэл хуудас, түүний бүрдэлд тавих үндсэн шаардлага” MNS6395:2022 стандартын дагуу үйлдсэн байна.	100%

6.4.	Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2024 оны А/110 дугаар тушаалаар баталсан “Хамгийн чухал нь” зорилтот арга хэмжээнд туссан холбогдох үйл ажиллагааг хэрэгжүүлэх	Үйл ажиллагаа	Эрүүл мэндийн үзлэг, оношилгоонд алба хаагчдын хамрагдсан хувь	-	90%	Хууль, зүй дотоод хэргийн сайдын 2024 оны А/110 дугаар тушаалаар баталсан "Хамгийн чухал нь" зорилтот арга хэмжээний хэрэгжилтийг хангаж Дорноговь аймгийн Нэгдсэн эмнэлэгт 2025 оны 04 дүгээр сарын 09,10-нд сумын улсын бүртгэгч нарыг, 04 дүгээр сарын 26-нд хэлтсийн албан хаагчид, Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлэг баг бүрэлдэхүүн тус аймагт ирж 2025 оны 05 дугаар сарын 22-нд эрүүл мэндийн эрт илрүүлэг, үзлэг оншилгоонд албан хаагчдыг бүрэн хамруулсан.	100%
6.5.	Алба хаагчдын болоод тэдгээрийн гэр бүл төрөл төрөгсдийн нийгмийн баталгааг хангах, учирсан эрсдлийг даван туулах чиглэлээр ажил зохион байгуулах	Үйл ажиллагаа	Төрийн болон төрийн бус байгууллага, хамт олноос алба хаагчдын нийгмийн баталгааг хангахаар зохион байгуулсан арга хэмжээний тоо	2	3	Тус хэлтсийн албан хаагчдын ажиллах нөхцлийг дэмжих, нийгмийн баталгааг хангах зорилтын хүрээнд Сайншанд хотод үйл ажиллагаа явуулдаг барилгын Энержи парагон ХХК, Гантулга трейд ХХК-ын удирдлагуудтай уулзалт зохион байгуулж Энержи парагон ХХК-ийн 2025 оны 3 дугаар улиралд ашиглалтанд орсон орон сууцнаас 1 албан хаагчид хөнгөлөлттэй үнээр, мөн Гантулга трейд ХХК-ийн Мандах наран хорооллын төрийн албан хаагчийн түрээсийн орон сууцанд 1 албан хаагчийг тус тус хамруулж нийгмийн баталгааг ханган ажилласан. Мөн Замын-Үүд сумын улсын бүртгэгч нарын гаргасан хүсэлтийн дагуу Замын-Үүд сумын Соёмбо багийн 6 дугаар хэсэгт баригдаж буй “Мандах наран-2” орон сууцанд хамруулахаар Дорноговь аймгийн Засаг даргын орлогч Г.Мартад 2025 оны 08 дугаар сарын 21-ний өдрийн 18/686 дугаар албан бичгээр хүсэлтийг хүргүүлсэн.	100%

ЗОРИЛТ 7. УЛСЫН БҮРТГЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЭРХ ЗҮЙН ОРЧНЫГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОЖ, УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХУУЛЬ ТОГТООМЖИЙГ ХЭРЭГЖҮҮЛНЭ.

7.1.	Улсын бүртгэлийн хэлтэст ирүүлсэн санал, өргөдөл, албан бичгийг хуулийн хугацаанд шийдвэрлэх	Үйл ажиллагаа	Шийдвэрлэсэн өргөдөл гомдлын хувь	98%	100%	Тус байгууллагад хагас жилийн байдлаар 57 иргэний өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг хүлээн авч, бүртгэлийн хяналтын карт хөтлөн хариуцсан албан хаагчид шилжүүлэн, өргөдлийг 100% шийдвэрлэн ажилласан. Хугацаа хэтэрч шийдвэрлэсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлт байхгүй.	100%
			Хариутай албан бичгийн шийдвэрлэлтийн хувь	90%	95%	Тайлант хугацаанд нийт ирсэн албан 1144 албан бичиг ирсэн бөгөөд үүнээс хариутай 662 албан бичгийг тухай бүр хууль, журмын дагуу шийдвэрлэн 94.8%-тай ажилласан.	99.7%
7.2.	Байгууллагын үйл ажиллагааг цахим болон хэвлэл, мэдээллийн хэрэгслээр сурталчилах	Үйл ажиллагаа	Байгууллагын веб хуудсан байршуулсан мэдээ, шторк, постерийн тоо	15	55	Аймгийн хэмжээнд “Мэдлэг түгээе”, “Мэдээлэл түгээе” аяныг эхлүүлэн үе шаттайгаар зохион байгуулан ажилласан. Энэ ажлын хүрээнд хэлтсээс үзүүлж буй хугацаатай бүртгэлийн мэдээллийг иргэд, олон нийтэд мэдлэг олгох үүднээс “МЭДЛЭГ ТҮГЭЭЕ” аян , байгууллагаас гарч байгаа мэдээ, мэдээллийг иргэд олон нийтэд сурталчилан “МЭДЭЭЛЭЛ ТҮГЭЭЕ” аяныг зохион байгуулан ажиллаж байна. Тайлант хугацаанд 10 сарын статистик тоон мэдээ, контент-3, рийл, видео ярилцлага-15, постер-49, пост-39, УБЕГ болон бусад мэдээ, мэдээллийг цахимд байршуулж 725701 иргэнд мэдээлэл хүргэсэн байна.	100%
7.3.	УБЕГ-аас болон бусад байгууллагаас зохион байгуулсан сургалтад хамрагдах	Үйл ажиллагаа	Хамрагдсан сургалтын тоо	8	10	УБЕГ болон бусад (авилга, хүний эрхийн комисоос “Хүүхдийн хүчирхийлэл”, Прокурор, АЗДТГ) байгууллагаас зохион байгуулсан танхимын 20 цахимын 16 нийт 36 сургалтад хэлтсийн дарга, тасгийн дарга болон зарим албан хаагчид хамрагдсан.	100%

7.4.	Улсын бүртгэлийн хэлтсийн хэмжээнд дагаж мөрдөх дүрэм, журам зааврыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулж, батлуулах	Үйл ажиллагаа	Боловсруулж батлуулсан журам, зааврын тоо	0	1	Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 243 дугаар тогтоолоор “Ахмадын сан байгуулан ажиллуулах журам”-ын дагуу тус хэлтсийн даргын 2025 оны А/21 дугаар тушаалаар “Ахмадын сан байгуулан ажиллах журам” баталсан. Ахмадын сангийн данс нээлгэх хүсэлтийг аймгийн Санхүү төрийн сангийн хэлтсээр дамжуулан Сангийн Яаманд хүргүүлсэн.	100%
7.5.	Эд хөрөнгө, хуулийн этгээд, иргэний улсын бүртгэлийн статистик тоон мэдээг нэгтгэн хүргүүлэх.	Үйл ажиллагаа	Батлагдсан маягтын дагуу статистик тоон мэдээг улсын хэмжээнд нэгтгэж, хүргүүлсэн тоо.	12	12	Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл, хуулийн этгээд, иргэний улсын бүртгэлийн статистик тоон мэдээг нэгтгэн сар бүрийн 25-ны өдрөөр тасалбар болгон УБЕГ-т хүргүүлсэн.	100%
7.6.	Хууль тогтоомжийн дагуу холбогдох этгээдэд улсын бүртгэлийн мэдээ тайлан, мэдээлэл хүргүүлэх, шаардлагатай бүртгэлийн мэдээ, тайланг гаргаж, удирдлагыг мэдээллээр хангах	Үйл ажиллагаа	Холбогдох байгууллагуудад хүргүүлсэн мэдээний тоо	2	4	Хөдөлмөр халамж үйлчилгээний газар, Нийгмийн даатгалын газарт сар бүрийн мэдээгээр бүртгэгдсэн иргэдийн мэдээлэл хүргүүлэн ажилласан. Мөн аймгийн Засаг даргад сар бүр хийсэн ажлын танилцуулгыг хураангуй хэлбэрээр гарган хүргүүлж удирдлагыг мэдээллээр ханган ажилласан. Аймгийн Татварын газарт эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн талаарх судалгааг улирал бүр гарган хүргүүлсэн.	100%
7.7	Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөтөлбөрийг дэмжин	Үйл ажиллагаа	Тарьж ургуулсан модны тоо	20	40	“Тэр бум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд тус байгууллага нь 950 хайлаас тод тарьсан. Үүнд: Дорноговь аймгийн Хамрын хийдийн 3 замын уулзвар Хилэнцэт хөшөөний дэргэд байрлах аялал жуулчлалын бүсийн ногоон байгууламжид 50 хайлаас, Хамрын хийдэд	100%

	ажиллах					байрлах “Энергийн элс” жуулчны баазад 100 хайлаас, иргэн С.Лхагвасүрэн мөн Д.Золбаяр нарын хашаанд хүлэмжийг тойруулан 800 ширхэг хайлаас мод тус тус тарьсан.	
--	---------	--	--	--	--	--	--

Төлөвлөгөөний биелэлтийг үнэлсэн:

УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА
(албан тушаал) (гарын үсэг)

Төсвийн шууд захирагч

/Д.ДАВААНЯМ/

(огноо).....

Тэмдэг

.....

Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн:

БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТ, ДҮН ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗРЫН ДАРГА...../Э.ГАНБАТ/
(албан тушаал) (гарын үсэг)

Нэгжийн дарга

(огноо).....

Тайлагнасан:

УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН ДАРГЫН АЛБАН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
(албан тушаал) (гарын үсэг)

Нэгжийн дарга

/С.ЭНХ-ЭРДЭНЭ/

(огноо).....